“Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн Гүйцэтгэх
захирлын 2021 оны 01 дүгээр сарын
26-ны өдрийн 10 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн сул, эзгүй орон тоог нөхөх ажилтан сонгон шалгаруулах, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Ажилтан сонгон шалгаруулахад Монгол Улсын үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, компанийн дүрэм, хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад хууль тогтоомж эрх зүйн актуудыг үндэслэл болгоно.

Хоёр. Сонгон шалгаруулалтанд оролцогчдын бүрдүүлэх материал

2.1 Ажилд орохыг хүссэн иргэн дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

2.1.1 Төрийн албан хаагчийн анкет

2.1.2 Ажилд орохыг хүссэн өргөдөл

2.1.3 Хөдөлмөрийн болон Нийгмийн даатгалын дэвтэр;/ажил эрхэлж байсан бол/

2.1.4 Урьд ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт;

2.1.5 Иргэний үнэмлэхний хуулбар;

2.1.6 Мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар;

2.1.7 Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл үндсэн эхээр;

2.1.8 Зэрэг, цолыг тодорхойлсон баримт;

2.1.9 3 үеийн намтар;

2.1.10 Зураг 4 хувь /3х4/;

2.1.11 Эрүүл мэндийн үзлэгийн дэвтэр;

2.1.12 Анкет хийх хавтас 1 ш

Гурав. Сонгон шалгаруулалтанд оролцогчдын материалыг хүлээн авах

3.1 Компаниас зарласан ажлын байранд заагдсан материалыг зар олон нийтэд зарлагдсан өдрөөс ажлын 10 хоногийн дотор хүлээн авна.

3.2 3.1-д заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд материалыг хүлээн авахгүй

3.3 Шаардлага хангаагүй материалыг оролцогчид буцаан олгож цаашдын сонгон шалгаруулалтанд оролцуулахгүй.

Дөрөв. Сонгон шалгаруулалтын зохион байгуулалт

4.1 Сонгон шалгаруулалт нь ярилцлага болон мэдлэг, ур чадвар сорилтын 2 үе шаттай байх бөгөөд ажилтан сонгон шалгаруулах ажлын хэсэг зохион байгуулна.

4.2 Мэдлэг, ур чадварын сорилтын асуулгыг тухайн сонгон шалгаруулах албан тушаалын дагуух мэргэжлийн албан хаагчаас санал авч сонгон шалгаруулах ажлын хэсгийн нарийн бичгийн дарга /цаашид "нарийн бичгийн дарга" гэх/ нэгтгэн боловсруулан Ажлын хэсгийн даргаар батлуулна.

Тав. Сонгон шалгаруулалтыг дүгнэх

5.1 Нарийн бичгийн дарга оролцогчдын шалгаруулалтанд тэнцсэн болон тэнцээгүй тухай мэдээг холбогдох утсаар болон цахим хаягаар шат бүрийн дараа хүргэн, дараагийн шатанд урьж шаардлагатай мэдээллийг хүргэнэ.

5.2 Сонгон шалгаруулалтад тэнцэн, өндөр оноо авч, эхний 2 байранд тэнцсэн ажил горилогчдыг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, шийдвэр гаргана.

Зургаа. Бусад зүйл

6.1 Сонгон шалгаруулалтын явцыг баримтжуулсан болон холбогдох баримт материалыг нарийн бичгийн дарга дараа оны 1 дүгээр улиралд багтаан архивт шилжүүлнэ.

6.2 Сонгон шалгаруулалтын үед гарсан аливаа санал, гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 1 хоногийн дотор сонгон шалгаруулалтын ажлын хэсэг шийдвэрлэнэ.

6.3 Ойлголцолд хүрээгүй тохиолдолд Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, гомдол гаргагчид бичгээр мэдээлнэ.